

**ШИНЖЛЭХ УХААНЫ
ХОЛБОО****МОНГОЛ, АМЕРИКИЙН
ЭРДЭМТДИЙН БАГА ХУРАЛ**

Н. ИШЖАМЦ, ШУА-ийн сурвалжлагч
гишүүн

Дорнодахины судлал, олон улсын харилцааны талаар БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ өргөжиж, социалист улсууд, бусад орны эрдэмтэдтэй харилцах харилцаа, хамтын ажиллагаанд ахиц гарсаар байна. Эрдэм шинжилгээний ажлын хэрэгцээ шаардлага, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилтын үүднээс олон орны эрдэмтэд хамтран ажиллах явдал чухал болж байна. Олон улсын тавцан дээр БНМАУ-ын нэр хүнд, байр суурь бэхжих тутам гадаадын эрдэмтэд манай улсыг сонирхох, монгол эрдэмтдийн бүтээл, санаа бодлыг улам их анхаарах болж байна.

1985 оны намар АНУ-ын Калифорни муж-улсын их сургуулийн Дорнод Азийн судлалын институтын захирал, засгийн профессор Р. А. Скалапино тэргүүтэй хэсэг эрдэмтэн БНМАУ-д зочилж, Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын тулгамдсан асуудлын талаар манай дорно дахинчид, гадаад харилцааны мэргэжлийн зарим хүмүүстэй уулзалт хийж, санал солилцоод буцсан юм.

Өнгөрсөн 1986 оны 12-р сарын 17—19-ний өдрүүдэд АНУ-ын Калифорни муж-улсын Бэркли хот дахь Калифорнийн Их сургуулийн Дорнод Азийн сургалтын институт дээр Монгол, Америкийн эрдэмтдийн бага хурал болж өнгөрөв. Номхон далай, Азийн бүс нутгийн улс орнуудын тулгамдсан асуудлаар хийгдсэн АНУ, Монголын хоёр талын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал дээр 10 гаруй илтгэл тавигдав. Америкийн талаас профессор Р. А. Скалапино «Номхон далай— Азийн бүс нутгийн хөгжилт», Монголын талаас академич Ш. Бира «Бүх нийтийн аюулгүй байдлын цар хүрээн дэх Ази-Номхон далайн бүс нутаг» гэсэн гол илтгэлүүдийг тавилаа. Америкийн талаас тус бага хуралд профессор Д. Хэлманн, Х. Хардинг, Дж. Каллгрэн, М. Бутон, Дж. Боссон зэрэг бас бус эрдэмтэд оролцож, илтгэл тавьж, үг хэлэв. Америкийн эрдэмтдийн илтгэлд гол төлөв бүс нутгийн эдийн засаг, нийгэм-улс төр, олон улсын харилцааны холбогдолтой асуудал тавигдсан бөгөөд энх тайвны асуудлын холбогдолтой нэг илтгэл: «Азийн аюулгүй байдал ба АНУ» (р. Скалапино) байв. Монголын талын гол илтгэл болон бусад бүх илтгэл, тухайлбал «Ази-Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх тухай БНМАУ-ын санал, санаачлагууд» (Ж. Энхсайхан), «Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, цөмийн ба үй олноор хөнөөгч бусад зэвсгийг устгах тухай асуудал» (Б. Дүгэр), «Цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын санаачилга» (Н. Ишжамц) нь энх тайван, аюулгүй байдал, цөмийн зэвсэг хураах асуудалд зориулагдсан байв.

Хүн төрөлхтөнд цөмийн сүйрлийн аюул заналхийлж байгаа орчин үед цөмийн дайн гаргахгүй байх, энх тайван, аюулгүй байдлын чухлыг монгол, америкийн эрдэмтэд үндсэндээ санал нэгтэй тэмдэглэн ярилцаж байв. Дайны аюулыг хэрхэн урьдчилан сэргийлэх, улс түмний аюулгүй байдал, энх тайвныг хэрхэн бэхжүүлэх арга зам, олон улсын харил цааны гол асуудлууд дээр хоёр талын санаа бодол нь зарчмын ялгаатай, энэ талаар санал зөрж байв. Гэвч хоёр тал бие биеийн санаа бодлыг илэн далангүй ярилцаж, эрдэм шинжилгээний төвшинд ул үндэстэй шүүмжлэн

хэлэлцэж, шууд санал солилцсон нь аль алиндаа ашигтай болохыг бага хурал тодорхой харуулав.

Бага хуралд оролцсон Монголын төлөөлөгчдийг 12-р сарын 22-ны өдөр АНУ-ын нийслэл Вашингтон хотод төрийн департаментад хүлээн авч хоёр талын эрдэм шинжилгээний бага хурал, Монгол-Америкийн харилцаа, олон улсын байдлын талаар санал солилцон ярилцав. Үүнээс гадна Смитсоны төв институт, түүний дэргэдэх Кеннаны институт, мөн Джорж Вашингтоны их сургууль дээр дорно дахины судлал, олон улсын судалгааны эрдэмтэн мэргэжилтэн нар бидэнтэй уулзаж ярилцав.

1986 оны 12-р сарын 23-24-ний өдрүүдэд бид Принстон хотод очиж Америкийн олон улсын судалгаа, солилцооны товчооны гүйцэтгэх захирал А. Кассоф, орлогч захирал Д. Матюшевки, тус байгууллагын нарийн бичгийн дарга Ребекка Парк, Төв Ази, олон улсын судалгааны бусад зарим мэргэжилтэн нартай уулзаж ярилцав.

Америкийн талтай хийсэн уулзалт, яриа найрсаг байдалд, үр дүнтэй болж өнгөрөв.

Америкийн тал Америк, Монголын хооронд дипломат харилцаа байгуулах, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ном хэвлэл солилцох, тус тусын хурал зөвлөлгөөнд харилцан оролцож байх зэргийг сонирхож байв. Монгол, Америк болон бусад улс орны эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд найрсаг харилцаа, бүтээлч хамтын ажиллагаа тогтох нь улс түмний харилцан итгэж ойлголцох, бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд зохих ач холбогдолтой билээ.

НАНЬЖИН ХОТНОО БОЛСОН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТУХАЙ

1986 оны 9-р сарын 22—26-ны хооронд Хятадын Наньжин хотноо «Юан гүрний түүх судлал» хэмээх эрдэм шинжилгээний чуулга уулзалт болов. Чуулга уулзалтад БНХАУ, Япон, АНУ, Сингапур, БНМАУ зэрэг таван орны зуугаад эрдэмтэд оролцож Наньжин, Хөх хот, Бээжин зэрэг гурван томоохон төвийн монгол судлал, ялангуяа дундад зууны үеийн Монголын түүхийн судлалын асуудлыг хөндөж ярилцав. Энэхүү Симпозиумд Монголын түүхийн судалгаагаар ажилладаг Хятадын томоохон эрдэмтэд оролцсоны гадна хуралд нийтдээ эрдэм шинжилгээний жараад илтгэл тавьж хэлэлцүүлжээ. Тавьсан илтгэлүүдийн гол агуулгыг ерөнхийд нь дүгнэж үзвэл ихэнхдээ Монголын нэгдсэн улс, Юан гүрний үеийн монголын түүхийн холбогдолтой сэдвүүдийг хөндөн бичиж, баримт материалыг үнэлэн цэгнэж өгүүлсэн байна.

Хятадын монгол судлалын нийгэмлэг ба Наньжин дахь Юан гүрний түүх судлах нийгэмлэгийн дарга профессор Цай Мэйбяо «Хятад дахь Юанын түүх судлах ажлын байдал» хэмээх илтгэл тавьж уг асуудлаар сүүлийн 10 жилд хийсэн ажлын байдал ба хойшид хийх ажлынхаа талаар хөндөж ярилаа.

Тус хурал дээр Монголын эрдэмтэн, академич Ш. Нацагдорж «БНМАУ-д Монголын феодализмын түүхийг судалсан байдал» гэдэг илтгэл тавьжээ. Тэрээр илтгэлдээ нүүдэлчин ард түмний дунд түүний дотор Монголд феодализм үүсч хөгжсөн талаар олон орны эрдэмтдийн баримталдаг янз бүрийн саналыг дурдаад, Монголын феодализмын түүхийг гүнзгий судалсныхаа дүнд Монголд феодалын ёс үүсч хөгжсөнийг түүхийн баримтаар нотлохын хамт нүүдлийн феодализм нь суурьшмал орны феодализмаас зарчмын ялгаагүй болохыг баталжээ. Монголын феодализ-